

“Сэтгүүл зүйн ёс зүйн форум” (JEF 2026)-д зориулан судалгаа хийж нотолгоонд суурилсан илтгэл танилцуулах гэрээт судлаач (2 хүн) сонгон шалгаруулах зар

Судалгааны зорилго

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ)-өөс уламжлал болгон зохион байгуулдаг “Сэтгүүл зүйн ёс зүйн форум” (JEF) нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, сэтгүүл зүйн ёс зүй, олон нийтийн итгэл, мэдээллийн орчны өөрчлөлт, технологийн нөлөө болон салбарын өмнө тулгамдаж буй асуудлуудыг олон талын оролцоотойгоор хэлэлцдэг мэргэжилтнүүдийн талбар юм.

Сүүлийн жилүүдэд Хиймэл оюун (AI)-д суурилсан хэрэгслүүдийг редакцын ажил, контент боловсруулах, хэлний хөрвүүлэг, мэдээлэл түгээх, дүрс болон видео контент бүтээх зэрэгт өргөн ашиглах болсон нь сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүй, редакцын хариуцлага, ил тод байдал, олон нийтийн итгэлтэй холбоотой шинэ сорилтуудыг бий болгож байна. ХМЗ-өөс 2026 оны 9 дүгээр сард зохион байгуулах “Сэтгүүл зүйн ёс зүйн форум”-аар хэвлэл мэдээллийн салбар дахь Хиймэл оюуны хэрэглээ, түүнтэй холбоотой ёс зүйн сорилт, олон нийтийн итгэл, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлын асуудлыг олон талт оролцоотойгоор хэлэлцэхээр төлөвлөж байна. Иймд форумын үеэр танилцуулах судалгааны илтгэлүүдийг мэргэжлийн түвшинд бэлтгэх, нотолгоонд суурилсан хэлэлцүүлгийн үндэс болгох зорилгоор судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр энэхүү сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

1. Судалгааны ажлын сэдэв болон хамрах хүрээ

- Судалгаа №01 нь JEF2026 форумын сэдэв, зорилготой уялдсан, Монголын хэвлэл мэдээллийн орчин дахь ёс зүйн болон технологийн шинэ сорилтуудыг нотолгоонд суурилан тайлбарласан байх. Үүнд, “**Хиймэл оюуны хэрэглээ ба сэтгүүл зүйн ёс зүйн эрсдэл**” сэдвээр “эх сурвалжийн ил тод байдал, ташаа мэдээлэл, зохиогчийн эрх, хүний нэр төр, хувийн мэдээлэл, алгоритмын алдаа, хариуцлагын асуудлыг” авч үзэх.
- Судалгаа №02 нь Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа болох сэтгүүл зүйн ёс зүй, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, Ёс зүйн хорооны шийдвэр, гомдлын чиг хандлага болон редакцын хариуцлагатай шууд уялдсан байх. Үүнд, “**Сэтгүүл зүйн ёс зүйн зарчмын хэрэгжилт: редакцын түвшний сорилт**” сэдвээр “ХМЗ-ийн ёс зүйн зарчмууд редакцын өдөр тутмын ажилд хэрхэн хэрэгжиж буй болон сэтгүүлч, редакторууд ямар нөхцөлд ёс зүйн шийдвэрийг хэрхэн гаргадаг, редакц дотооддоо ёс зүйн хяналт, засвар, залруулгын ямар механизм ашиглаж буй, ХМЗ ба редакцын харилцаа холбоо”-г судлах.

2. Судалгааны зохион байгуулалт, техникийн шаардлага

Судалгаа нь ном зохиол (ашигласан бүтээлийн жагсаалт), хүснэгт, зургийг оруулалгүйгээр 7000-9000 үгэнд багтаж бичигдсэн байна.

2.1. Судалгааг дараах дарааллаар бичнэ:

1. Судалгааны нэр: Энэ нь судалгааны бүтээлийн агуулгыг илэрхийлэхүйцээр оновчтой томъёолсон байна. Шаардлагатай нөхцөлд дэд гарчгийг нэмж болно. Бичиглэл: Arial 14, бүгдийг том үсгээр, нүүрийг голлуулж бичнэ.
2. Зохиогчдын мэдээлэл: Зохиогчдын овог нэр, эрдмийн зэрэг цол, албан тушаалыг бичнэ. Үүнээс доош бичиглэл: Arial 12, Sentence case, хоёр талаас тэгшилж бичнэ.

3. Түлхүүр үгс: Судалгааны агуулгыг илэрхийлэх зориулалттай 5-аас илүүгүй түлхүүр үгийг оруулна. Түлхүүр үгэнд гарчигт орсон үгсийг давтаж оруулахаас зайлсхийнэ.
4. Оршил: Асуудлын үндэслэл, судлах шаардлага, форумын сэдэвтэй холбогдох байдлыг тоймлон, улмаар өөрсдийн судалгааны зорилго, дэвшүүлсэн таамаглал зэргийг тусгана.
5. Үндсэн хэсэг: Дэвшүүлсэн таамаглалыг батлах зорилго зорилт бүхий материал ба арга зүй, үр дүн хэсгээс бүрдэнэ.
6. Дүгнэлт
7. Практик зөвлөмж: Редакц, сэтгүүлч, ХМЗ, бодлого боловсруулагчдад чиглэсэн санал
8. Эшлэл
9. Ашигласан бүтээлийн жагсаалт
10. Хураангуй

2.2. Арга зүйн шаардлага

Судалгаа нь заавал нотолгоонд суурилсан, эх сурвалж тодорхой, дүгнэлт ба зөвлөмж нь бодит хэрэглээнд чиглэсэн байна. Судалгааны илтгэл нь дараах аргуудын аль нэг эсвэл хосолсон хэлбэрт тулгуурлаж болно.

- Баримт бичгийн шинжилгээ;
- Хэвлэл мэдээллийн контентын шинжилгээ;
- Сэтгүүлч, редактор, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөлтэй ярилцлага;
- Асуулга судалгаа;
- Кейс судалгаа;
- Олон улсын туршлагын харьцуулсан шинжилгээ;
- Платформ, хиймэл оюун, баримт шалгах хэрэгслийн хэрэглээний жишээ шинжилгээ.

2.3. Илтгэлд тавих шаардлага

- Судлаач нь форумын өмнөх бэлтгэл уулзалтад оролцож, зохион байгуулагчдын саналын дагуу илтгэл слайдыг сайжруулах боломжтой байх.

3. Хүлээгдэж буй бүтээгдэхүүн, хугацаа, тэтгэлэг

Сонгогдсон судлаач дараах бүтээгдэхүүнийг бэлтгэнэ.

1. Судалгааны бүтээл: 7500–10000 үг
2. “Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2026” дээр танилцуулах илтгэл: 20 минут
3. PPT танилцуулга: 10–15 слайд
4. Асуулт, хариултад оролцох: 20 минут
5. Бодлогын болон практик зөвлөмж: 1–2 хуудас

Судалгаа гүйцэтгэх хугацаа: 2025 оны 6-р сарын 01-нээс 9-р сарын 05 хүртэл

Судалгааны тэтгэлэг: нийт 3-4 сая төгрөг (хоёр судлаач)

4. Сонгон шалгаруулалтын шалгуур

Шалгуур	Оноо
Сэдвийн JEF 2026 форумын зорилготой нийцэх байдал	25
Судалгааны арга зүйн тодорхой байдал	20
Шинэлэг байдал, ач холбогдол	20
Ёс зүйн болон өөрийн зохицуулалтын асуудалтай холбосон байдал	25
Практик зөвлөмж гаргах боломж	10
Нийт	100

Материал хүлээн авах:

Сонирхсон судлаачид дараах мэдээллийг нэгтгэсэн файлаар илгээнэ:

- Илтгэлийн сэдэв
- 500 хүртэл үгийн хураангуй (судалгааны зорилго, асуулт, таамаглал)
- Ашиглах арга зүй
- Урьдчилсан бүтэц
- Илтгэгчийн товч танилцуулга
- Холбоо барих мэдээлэл
- Өмнөх судалгаа, бүтээлийн жагсаалт, боломжтой бол тэдгээрийн холбоос

Материалуудыг нэгтгэн нэг файлаар монгол болон англи хэлээр 2025 оны 6 дугаар сарын 12-ны дотор дараах хаягаар илгээнэ үү:

Хэнд: Хэвлэл Мэдээллийн Зөвлөл

Гарчиг: JEF Судалгаа боловсруулах, илтгэл танилцуулах

И-мэйл: bolormaa@mediacouncil.mn

“Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2026”-г Европын Холбооны дэмжлэгтэй “Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл дэмжин ажиллах болно.

Төслийн зорилго: Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академи (DWA)-тай хамтран “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний Нийгмийн Байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг 2023-2026 онд Европын Холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд ИНБ-уудын ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах үндсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Төсөл хэрэгжүүлэгчдийн тухайд:

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, хамтын ажиллагааны үр дүнд 2015 оны эхээр байгуулагдсан хэвлэмэл, цахим сайт, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага юм.

ХМЗ нь олон нийтийн сонирхолд үйлчилснээр хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчдийг мэргэжлийн сэтүүлзүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд нь тусалдаг. Ингэхдээ бид Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн хэмээн үзэж буй иргэн, хуулийн этгээдийн гомдлыг үнэ төлбөргүй бөгөөд шударгаар хэлэлцэж шийдвэр гаргадаг. Түүнчлэн ХМЗ нь хэвлэлийн эрх чөлөө, бие даасан ёс зүйтэй хэвлэл мэдээлэл, хариуцлагатай, ил тод ИНБ-уудыг чадавхжуулан бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах олон талт төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Дойче Велле Академи (DW Akademie) нь ХБНГУ-ын Дойче Веллегийн олон улсын хэвлэл мэдээллийн хөгжил, сэтгүүл зүйн сургалт, мэдлэгийн солилцооны төв юм. Дойче Велле Академийн төслүүд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэлд саадгүй хүрэх хүний эрхийг бэхжүүлэхэд чиглэдэг. Дойче Велле Академи нь дэлхийн эргэн тойронд хүмүүсийг найдвартай баримт, бүтээлч хэлэлцүүлэгт тулгуурлан бие даан шийдвэр гаргах чадвартай болгоход дэмжлэг үзүүлдэг. Дойче Велле Академи нь ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны стратегийн түнш бөгөөд Холбооны Гадаад хэргийн яам, Европын Холбооноос санхүүжилт авч, дэлхийн 70 орчим хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудад идэвхтэй ажилладаг.